



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
АЖЛЫН ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2026 он**

**ИРГЭНИЙ ГАРГАСАН ГОМДЛЫН ДАГУУ ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ-СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛСАН “НҮҮДЭЛЧИН”
НААДМЫН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ
ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 01 дүгээр сарын 26-ний өдөр

Улаанбаатар хот

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 12 сарын 18-ны өдөр баталсан “Иргэний гаргасан гомдлын дагуу засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Соёл, урлагийн газрын зохион байгуулсан “Нүүдэлчин” наадмын төсвийн зарцуулалтын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалт хийх удирдамж”-ын хүрээнд Авлигатай тэмцэх газрын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 05/19641 дүгээр албан бичигт дурдагдсан асуудлаар дотоод хяналт шалгалт хийж, дүгнэлт гарган, цаашид авах арга хэмжээний санал боловсрууллаа.

Шалгалтын ажлын хэсгийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга Д.Түмэндэмбэрэл ахалж, ахлах шинжээч Ц.Алтанхуяг, шинжээч Г.Шүрэндолгор нар гүйцэтгэлээ.

Батлагдсан удирдамжийн “Тав.Хяналт шалгалтын хамрах хүрээ, чиглэл” хэсэгт заасны дагуу гомдолд дурдсан асуудлаар дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн болно.

НҮҮДЭЛЧИН НААДМЫН ТУХАЙ

Тус наадам анх 1948 оноос “Ерөөлч магтаалчдын улсын анхдугаар уралдаан”, 1966 оноос “Ардын язгуур урлагийн наадам”, 1991 оноос “Ардын урлагийн их наадам” нэрээр улсын хэмжээнд зохион байгуулж ирсэн түүхэн уламжлалтай.

Улаанбаатар хотын Хүй долоон худагт “Нүүдэлчин Монгол” соёлын биет бус өвийн их наадам нэрээр 2018 онд биет бус өвийн хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2003 оны конвенцын зарчим, үзэл баримтлалын дагуу 5 ай савын хүрээнд зохион байгуулагдсан.

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль нэрээр 2022 оноос зохион байгуулж эхэлсэн бөгөөд Засгийн газрын 2024 оны “Фестиваль” зохион байгуулах асуудлаарх 41 дүгээр тогтоолоор тус фестивалийг жил бүр зохион байгуулах шийдвэр гарч, соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд зохион байгуулж байна. Тус фестивальд 2025 онд нүүдэлчдийн соёлын өвийг өвлөн эзэмшиж буй аймаг, нийслэлийн 1091 өвлөн уламжлагч, шавь суралцагчид, мөн 27 улсын 280 гаруй зочид төлөөлөгч, тамирчин, давхардсан тоогоор 260,000 гаруй үзэгч, иргэд, жуулчид хүрэлцэн ирж оролцсон бол 620,000 гаруй иргэдэд мэдээллийг цахимаар түгээсэн байна. Биеэр ирж сонирхсон үзэгч жуулчдын үзүүлэлт нь өнгөрсөн жилээс 53%-иар өссөн. Түүнчлэн фестивалийн үеэр зөвхөн “Нүүдэлчин зоог” аялал жуулчлалын хоолны гудамжинд үйл ажиллагаа явуулсан хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд нийтдээ 1.8 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлсэн дүн гарсан байна.

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ТОГТООГДСОН БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. ...“Нүүдэлчин” соёлын наадмын үеэр худалдан авах ажиллагааг хууль бусаар зохион байгуулж, улсын төсвийн хөрөнгийг хувьдаа завшиж, шамшигдуулсан. Тухайлбал нийт 3.0 тэрбум төгрөгийн төсвийн хөрөнгийг тендергүйгээр худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан. Тендер зарлахгүй бүх төсвийг жижиглэн хувааж, 20 саяас бага болгож худалдан авалтыг хийсэн”... тухай асуудлыг шалгахад:

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг (цаашид “фестиваль” гэх) зохион байгуулахтай холбоотой Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн “Зардал баталж эрх шилжүүлэх тухай” А/77 дугаар тушаалаар 3,000,000.0 мянган төгрөг, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Соёл урлагийн газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Мөнгөн хөрөнгө зарцуулах тухай” А/35 дугаар тушаалын хавсралтаар “Нүүдэлчин” фестиваль зохион байгуулахад шаардагдах 2,999,945,5 мянган төгрөгийн зардлыг баталжээ.

Фестиваль зохион байгуулах зардлыг баталж, эрх шилжүүлсэн тушаалыг 2025 оны 03-р сарын 07-ны өдөр баталсан боловч санхүүжилтийн эрх нээлгэх явц удаашралтай байсан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Сангийн сайд уруу 2025 оны 04 дүгээр сарын 03-ны 01/916 дугаартай албан бичиг хүргүүлж, удаа дараа холбогдох уулзалт хийж байсан байна. Гэвч улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор эрх шилжүүлж байгаа санхүүжилтийн эрхийг 2025 оны 07 дугаар сарын 09-нд 2025 оны Төсвийн тухай хуульд тодотгол орсноор санхүүжилт нээгдэх боломжтой болсон байна.

Мөн ЗГХА-Соёл, урлагийн газрын даргыг 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн Б/18 тушаалаар чөлөөлж төсвийн шууд захирагч солигдсон нь Нүүдэлчин фестивалийн зохион байгуулалтын ажил удаашрахад нөлөөлжээ.

Санхүүжилтийн эрхийг дахин нээлгэх хүсэлтийг 08 дугаар сарын 05-нд хүргүүлж, Сангийн яамнаас 08 дугаар сарын 19-нд эрхийг нээж, шилжүүлгийг 08 дугаар сарын 19-ний өдөр болон 20-ны өдрүүдэд 2 хуваан Соёл урлагийн газарт шилжүүлсэн байна.

Фестивалийн зардлын төсөв гүйцэтгэлийн хураангуйг хүснэгт 1-ээр харуулав.

“Нүүдэлчин” фестивальд зарцуулагдсан төсвийн задаргаа

Хүснэгт 1 /Мянган төгрөгөөр/

№	Зардлын утга	Арга хэмжээний тоо	төсөв	Гүйцэтгэл
1	Зохион байгуулалтын зардал	18	204,475.00	185,406.00
2	Дэд бүтэц, тохижилтын зардал	12	301,100.00	186,670.00
3	Соёлын өвийн үзлэг, өртөөний зохион байгуулалтын зардал	17	655,550.00	655,043.00
4	Гадаад оролцогч, зочид төлөөлөгчдийн зардал	5	107,250.00	105,724.00
5	Ази номхон далайн бүс нутгийн 23 улсын Соёл, урлагийн сургуулиудын судлаачдын зөвлөгөөнийг зохион байгуулах	1	20,000.00	20,000.00
6	Өвлөн уламжлагчдыг алдаршуулах зардал	3	85,000.00	84,522.00

7	Их тайзны зохион байгуулалтын зардал	9	289,000.00	279,300.00
8	Үндэсний спортын уралдаан, тэмцээний зардал	2	220,000.00	220,000.00
9	Аялал жуулчлалын гудамж, хоол үйлчилгээний зардал	0	-	-
10	Оролцогч, зохион байгуулагч нарын хоол үйлчилгээний зардал	13	421,000.00	419,933.54
11	Нийтлэг үйлчилгээ, тээвэр логистикийн зардал	1	348,130.00	348,130.00
12	Маркетинг, контент, сурталчилгааны зардал	7	348,440.00	327,580.00
Нийт		88	2,999,950.0	2,832,310.0

Зардлын төсвийг 12 үндсэн үйл ажиллагааны 7 дэсэг, 88 бараа, ажил, үйлчилгээтэй байхаар төсөвлөсөн. Үүнд: 1. Ерөнхий зохион байгуулалтын зардлын бүлгийг дотор нь 4 дэд хэсэг, 3.Соёлын өвийн үзлэг, өртөөний зохион байгуулалтын зардлын бүлгийг 2 дэд хэсэг, 7.Их тайзны зохион байгуулалтын зардлын бүлгийг 2 дэд хэсэгтэй ба бусад үндсэн хэсгүүд дэд хэсэггүй байна.

Тус тушаалаар нийт 2,999,945.5 мянган төгрөгийн нийт 88 бараа, ажил, үйлчилгээний зардлыг төлөвлөсөн байгаагаас 54 бараа, ажил, үйлчилгээний зардал нь Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-ын шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар (20 сая)-т багтсан, үлдсэн 28 бараа, ажил, үйлчилгээ нь дээрх тогтоолын Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар(100-150 сая)-т багтааж төсөвлөсөн байна.

Үүнээс 1,079,311.0 мянган төгрөгийн 15 бараа, ажил, үйлчилгээнд тендер зарлаж 12 багцтай 371,000.0 мянган төгрөгийн төсөвтэй “Оролцогч зохион байгуулагч нарын хоол үйлчилгээний тендер”, 16,786.0 мянган төгрөгийн төсөвтэй “Тээврийн үйлчилгээ”-ний тендер гэсэн 2 тендер амжилттай болж гэрээ хийгдсэн байна.

Бусад бараа, ажил, үйлчилгээний тендер нь нэг ч оролцогч тендерт материал ирүүлээгүйгээс амжилтгүй болсон. Гадаад оролцогч нарын байр, гадаадын оролцогч нарын автомашин түрээсийн үйлчилгээ гэсэн 2 тендерт тус бүр 1 оролцогч оролцож баримт материал дутуу ирүүлсэн шалтгаанаар сонгон шалгаруулалтад тэнцээгүй байна.

Үүнээс гадна тендер зарлах шаардлагатай 310,900.0 мянган төгрөгний 8 ажил, үйлчилгээнд тендер зарлаагүй шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна. Үүнд:

Тендер зарлаагүй бараа, ажил, үйлчилгээний жагсаалт

Хүснэгт2 /мянган төгрөгөөр/

№	Утга	Тушаалын мөнгөн дүн	Гүйцэтгэгч	Гэрээний дүн
1	Нийт талбайн гэрэлтүүлэг (прожектор)	22,900.0	Налайх дүүргийн гэрэлтүүлэг	22,896.72

			чимэглэлийн алба/СУГ2025- 124/	
2	Угтах хэсгийн тохижилт дааман хаалга	25,000.0	Иргэн Г.Ганбаатар СУГ/	25,000.0
3	Тбб-ын оролцоог хангах зардал	40,000.0	9 төрийн бус байгууллага 1 иргэн	34,500.0
4	Их тайз, карказ, тавцан түрээс	45,000.0	Үндэсний урлагийн их театр	223,000.0
5	Тайзны тоног төхөөрөмжийн зардал	53,000.0		
6	Тайзны чимэглэл	35,000.0		
7	Нээлтийн үйл ажиллагааны зардал	60,000.0		
8	Хаалтын үйл ажиллагааны зардал	30,000.0		
	Нийт дүн	310,900.0		

Хоёр. “...Тендерийг ажлын бус цагаар зарлаж, 1 өдрийн дотор нээж хаасан. Зориуд зохион байгуулалттай өөрийн бэлдсэн компани, хүмүүсээ оруулахын тулд хуулийн хугацааг өөрчилсөн. Хоолны тендерийг урьдчилан тохиролцож материалыг нь бэлдүүлснээр “Модерн Номадс” ХХК”-д өгсөн, “Нүүдэлчин” наадмын худалдан авалтаар хууль бус гэрээг өөрийн эгч С.Сувд-Эрдэнэ, мэргэжилтэн Ж.Насанжаргал, М.Түмэнжаргал нартай үгсэн хуйвалдаж тохиролцож хийлгүүлсэн...” гэх асуудлыг шалгахад:

Нүүдэлчин фестивалийг зохион байгуулахад шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Соёл урлагийн газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/44 дүгээр тушаалаар баталсан байна. Тус тушаалаар:

1.Ерөнхий зохион байгуулалтын ажил, Өвлөн уламжлагчдыг алдаршуулах бүтээгдэхүүн худалдан авах тендер шалгаруулалтын гүйцэтгэгч сонгох Үнэлгээний хороо;

2.Дэд бүтэц, тохижилтын ажил, Оролцогч, зохион байгуулах байгуулагч нарын хоолны үйлчилгээний тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо;

3. Гадаадын оролцогч зочид, төлөөлөгчдийг хүлээн авах үйлчилгээ, Маркетинг контент, сурталчилгааны ажлын тендер шалгаруулалтын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороог тус тус байгуулсан байна.

Эдгээр Үнэлгээний хороод 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдөр болон 13-ны өдрүүдэд сонгон шалгаруулалтыг зарлаж, 2025 оны 08 дугаар сарын 14 болон 15-ны өдөр тендерийг хааж, Үнэлгээний хороодууд сонгон шалгаруулалтыг явуулсан байна.

Үнэлгээний 3 хороо “Нүүдэлчин” фестивалийн 1,079,311.0 мянган төгрөгийн доорх 15 бараа, ажил, үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 3/ мянган төгрөгөөр/

№	Тендерийн нэр	Тендерийн дугаар		Тайлбар
1.Ерөнхий зохион байгуулалтын ажил, Өвлөн уламжлагчдыг алдаршуулах бүтээгдэхүүн худалдан авах тендер шалгаруулалтын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороо;				
1.	Машингүй бүсэд үйлчлэх жижиг оврын автобус үйлчилгээ	СУГ/20250303048	24,000.0	Шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй
2.	Сайн дурын ажилтнуудын үйлчилгээ	СУГ/20250303046	24,000.0	Шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй
3.	Хамгаалалтын үйлчилгээ	СУГ/20250303047	10,000.0	Шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй
4.	Аймаг нийслэлийн оролцогчдын мерч бүтээгдэхүүн худалдан авах	СУГ/20250303055	60,000.0	Шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй
5	Тээврийн үйлчилгээ	СУГ/20250303060	16,786.0	Баялаг индерт ХХК шалгарсан.
	Дүн		134,786.0	
2.Дэд бүтэц, тохижилтын ажил, Оролцогч, зохион байгуулах байгуулагч нарын хоолны үйлчилгээний тендер шалгаруулалт үнэлгээний хороо				
1.	Генератор, сэргээгдэх эрчим хүч түрээсийн үйлчилгээ	СУГ/20250303050	52,800.0	Шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй
2.	Талбайн тохижилтод байрлуулах уран бүтээлийн үйлчилгээ	СУГ/20250303051	50,000.0	Шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй
3.	Тулга түрээсийн үйлчилгээ	СУГ/20250303052	10,000.0	Шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй
4.	Хэвлэлийн бүтээгдэхүүн худалдан авах, суурилуулах ажил	СУГ/20250303049	83,175.0	Шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй
5.	Оролцогч зохион байгуулагч нарын хоол үйлчилгээ (12 багц)	СУГ/20250303056	371,000.0	12 Багцтай Номадс хоспиталити ХХК шалгарсан
	Дүн		566,975.0	
3. Гадаадын оролцогч зочид, төлөөлөгчдийн хүлээн авах үйлчилгээ, Маркетинг контент, сурталчилгааны ажлын тендер шалгаруулалтын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороо				

1	Гадаад оролцогч улсын автомашин түрээсийн үйлчилгээ	СУГ/20250303053	18,000.0	Шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй
2	Гадаад оролцогчдын байрны үйлчилгээ	СУГ/20250303054	56,250.0	2 байгууллага тендер оролцсон шалгараагүй
3	Маркетингийн сурталчилгаа, контент бүтээх ажил	СУГ/20250303057	195,000.0	1 байгууллага тендер оролцсон боловч шалгараагүй
4	Портер, мэдээ бэлтгэх, сошиал сувгаар түгээх	СУГ/20250303058	73,300.0	Шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй
5.	Шууд дамжуулалт	СУГ/20250303059	35,000.0	Шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй
	Дүн		377,550.0	

Оролцогч, зохион байгуулагч нарын хоол үйлчилгээ (12 багц) тендерийг хуулийн дагуу урилга хүргүүлж 9 байгууллага хэлэлцээрт оролцсон байна. Тендер нээхэд 1 оролцогч буюу Номадс Хоспиталити ХХК 12 багцад бүгдэд нь оролцохоор материалаа ирүүлж, сонгон шалгаруулалтад оролцон шалгарсан байна.

Гурав. “...Мэргэжилтэн М.Түмэнжаргал өмнөх жилүүдэд хийгдсэн байсан ажлыг дахин шинээр хийсэн мэтээр гэрээ байгуулж, төсвийн мөнгийг хувьдаа завшсаар байна. Жишээ нь: Нүүдэлчин наадмын цахим хуудсыг өмнөх жилүүдэд хийсэн байтал дахин хийлгэх, хөгжүүлэх нэрийдлээр 19,520.0 мянган төгрөг, “Нүүдэлчин” наадмын талбайн авто зам, явган хүний замыг сайжруулах, тэгшлэх нэрийдлээр 19,600.0 мянган төгрөг, өмнө жилд авсан байсан гэрэл, гэрэлтүүлэг, цахилгааны утсыг худалдан авах нэрийдлээр дахин төсвийг суулгаж, удаа дараа гэрээ байгуулж мөнгө гаргаж авдаг. Жишээ нь “Миг степ” ХХК, “Мон хорус сервис” ХХК-д мөнгө шилжүүлсэн...” гэх асуудлыг шалгахад:

3.1.”Нүүдэлчин” фестивалийн цахим хуудасны төсөв, зарцуулалтын тухай:

Нүүдэлчин наадмын цахим хуудсыг анх 2023 онд (nomadsworldfestival.com) Соёл, урлагийн газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн “Мөнгөн хөрөнгө зарцуулах тухай” А/24 дүгээр тушаалд үндэслэж, 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн СУГ/2013-55 дугаар гэрээгээр “Богд вүүдс солюшн” ХХК-аар 4,400.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгүүлсэн байна.

Тус зардлыг Соёл, урлагийн газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн “Мөнгөн хөрөнгө зарцуулах тухай” А/24 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан зохион байгуулалтын зардлын төсөвтэй тулган шалгахад хавсралтын 1.3-т “Вэб сайт хөгжүүлэх зардал” гэсэн 20,000.0 мянган төгрөгийн төсөвтэй зардал байна. Тус зардлын гүйцэтгэлийг шалгахад зардлыг 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн СУГ/2023-52 дугаар гэрээгээр “Бүтээлч монгол гэрэлт ирээдүй” НҮТББ-аар хийж гүйцэтгүүлэхээр гэрээлсэн байх ба гэрээний гуравдугаар хавсралтаар дараах ажлын даалгаврыг хийж гүйцэтгэхээр баталсан байна. Үүнд:

-Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийн ерөнхий төлөвлөгөөний дагуу мэдээлэл боловсруулах;

-Соёлын биет бус өвийн ай савын талаарх 362 мэдээлэл бэлтгэх;

-Мэдээ, мэдээллийн дизайн хийх;

-Nomadsworldfestival.com сайтыг хүлээн авах, хариуцан ажиллах;
 -СУГ-ын фэйсбүүк хуудас дээр “Нүүдэлчин” фестивалтай холбоотой хөгжүүлэлтийг хийх.

“Бүтээлч монгол гэрэлт ирээдүй” НҮТББ-аас гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайланд “...”Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийн хүрээнд тус фестивалийн вэб сайтын хөгжүүлэлт, ЗГХА-СУГ-ын пэйж хуудсыг хөгжүүлэх ажлыг 2023 оны 06 дугаар сарын 01-ээс 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн хугацаанд чанарын өндөр түвшинд гүйцэтгэж ажиллав...; ...Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийн цахим вэб сайт болох вэб сайт нь хөгжүүлэлт хийхэд тохиромжгүй, динамик сайт байгаагүй тул Захиалагч талд санал хүсэлт тавьсны дагуу www.nomadsworldfestival.com вэб сайтыг шинээр хийлгүүлж ажилласан болно...” гэжээ.

Мөн “...Вэб сайт хөгжүүлэлт хийхэд манай Төрийн бус байгууллагаас дараах бүрэлдэхүүнтэй багийг ажиллуулсан болно.Үүнд:

Чиг үүрэг	Овог нэр	Ажлын үүрэг	Ажилласан хугацаа	Ажлын хөлс
Судлаач	Ү.Алтанхуяг	Соёлын биет бус өвийн 7 ай савын 362 өвийн мэдээлэл бэлтгэх	2023.05 сараас 08 сар хүртэл	3,000,000 төгрөг
	Д.Баярнэмэх			3,000,000 төгрөг
	Г.Очбаяр			3,000,000 төгрөг
Эх бэлтгэл	А.Ананд	Хэвлэлийн эх бэлтгэл	2023.05 сараас 08 сарын 21	4,000,000 төгрөг
Сошиал медиа хөгжүүлэлт	Б.Балжинням	Вэб сайт болон пэйж хуудаст мэдээ оруулах		1,750,000 төгрөг
Редактор	М.Мөнхсайхан	Бүх мэдээллийг редактор хийх		4,000,000 төгрөг
Нарийн бичиг, туслан гүйцэтгэгч	Х.Номинзул	Зохион байгуулалтын багийн туслах		1,250,000 төгрөг



гэж тайландаа тусгажээ.

СУГ/2023-52 дугаар гэрээгээр “Бүтээлч монгол гэрэлт ирээдүй” НҮТББ-аар хийж гүйцэтгүүлсэн гэрээний хэрэгжилтийг 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдөр “Гэрээ дүгнэх акт”-аар дүгнэж, гэрээний дүн болох 20,000.0 мянган төгрөгийг бүрэн шилжүүлсэн байна.

“Бүтээлч монгол гэрэлт ирээдүй” НҮТББ-тай хийсэн гэрээ болон гүйцэтгэгч байгууллагын тайлан, гэрээ дүгнэсэн акт зэргийг шалгахад тус байгууллагын зарцуулсан зардалд цахим хуудас шинээр бүтээхэд зардал зарцуулаагүй ба харин цахим хуудсанд тавигдах мэдээллийг бэлтгэх, мэдээллийг оруулах ажил хийгдсэн байна.

“Богд вүүдс солюшн” ХХК-тай байгуулсан 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн СУГ/2013-55 дугаар гэрээний нэгдүгээр хавсралтад домэйн хаягны төлбөрийг тусгаж, төлбөрийг гэрээний дагуу шилжүүлсэн байгаа боловч домэйн хаяг захиалагч байгууллага(Соёл, урлагийн газар)-ын нэр дээр бүртгэгдээгүй гүйцэтгэгч байгууллага (Богд вүүд солюшн)-ын нэр дээр бүртгэсэн байна. Захиалагч байгууллагын нэр дээр бүртгэгдээгүй учраас хостинг үйлчилгээний төлбөрийг төлөхөд хүндрэл үүссэн байна. Иймд 2023 онд шинээр хөгжүүлсэн цахим хуудсыг ашиглалгүй, дахин “Вэб хөгжүүлэх зардал”-ыг 19,520.0 мянган төгрөгөөр төсөвлөн СУГ-ын даргын 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/35 дугаар тушаалаар батлуулж, 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн СУГ/2025-129 дугаар гэрээг фестивалийн Вэб нээх(www.nwf.mn), хөгжүүлэх ажил гүйцэтгэх зорилгоор “Гэрэгэ пэй ХХК”-тай байгуулсан байна. Гэрээний нэгдүгээр хавсралтаар доорх ажлыг хийхээр тохиролцсон байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын 2025 оны 08 сарын 11-ны өдрийн СУГ/2025-129 дугаар гэрээний нэгдүгээр хавсралт

“НҮҮДЭЛЧИН ДЭЛХИЙН ФЕСТИВАЛЬ” БҮРТГЭЛИЙН СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зардлын мэдээлэл	Үнийн мэдээлэл		1 жилийн домайн
Веб систем хөгжүүлэлт				
1	Үндсэн дизайн гаргах	4,000,000	хөгжүүлэлт	1 3,000,000
2	Back-end хөгжүүлэлт	5,000,000	хөгжүүлэлт	1 5,000,000
3	Front-end хөгжүүлэлт	5,000,000	хөгжүүлэлт	1 4,500,000
4	Төслийн менежмент	5,000,000	хөгжүүлэлт	1 4,500,000
Домайн болон бусад зардал				
	Домайн авах	165,000	жил	1 165,000
	Домайн SSL	365,000	жил	1 365,000
Нийт				17,530,000
НӨАТ орсон дүн				1,990,500
				19,520,500

-oOo-

“Гэрэгэ пэй ХХК”-тай байгуулсан гэрээнд цахим хуудасны хостинг үйлчилгээний төлбөрийг мөн тусгаагүй байна. “Гэрэгэ пэй ХХК” наадмын үеэр хостинг үйлчилгээний төлбөрийг түр хугацаанд өөрөөсөө төлж, цахим хуудсыг ажиллуулж байгаад фестивал дууссаны дараа 2025 онд хөгжүүлсэн цахим хуудас ажиллахгүй болжээ.

Цаашид хостинг үйлчилгээний төлбөр төлөгдөхгүй бол тус цахим хуудас ч дахин ашиглагдахгүй байсаар устах эрсдэл үүссэн байна.

Нүүдэлчин наадмын анхны цахим(nomadsworldfestival.com)-ны 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн СУГ/2013-55 дугаар гэрээгээр “Богд вүүдс солюшн” ХХК-тай хийсэн гэрээг Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Мөнхзул баталж захиалагч талыг төлөөлж Соёл, соёл өвийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Ууганцэцэг нар гарын үсэг зурсан байна. Харин дахин хийлгэсэн цахим хуудас(www.nwf.mn)-ны 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн СУГ/2025-129 дугаар “Гэрэгэ пэй ХХК”-тай байгуулсан гэрээг Соёл, урлагийн газрын даргын

албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Цэнд-Аюуш баталж захиалагч талыг төлөөлж Соёл, соёл өвийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Насанжаргал, Захиргаа удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Сувд-Эрдэнэ нар гарын үсэг зурсан байна.

3.2. “Нүүдэлчин” наадмын талбайн авто зам, явган хүний замыг сайжруулах, тэгшлэх зардлын тухай:

Фестиваль зохион байгуулагддаг Улаанбаатар хотын Налайх дүүрэг Тайж хайрхны бэл нь дэд бүтэц хөгжөөгүй, зам талбай байхгүй тал газар зохион байгуулагддаг ба фестивалийн үеэр жил бүр дэд бүтэц, тохижилтыг хийж ирсэн байна.

Ингэхдээ фестивалийн зохион байгуулалтын ерөнхий ажлын хэсэг фестиваль болох газрыг очиж үзэн, хийх ажлуудыг тодорхойлж, чиглэл өгөн холбогдох албан хаагчдыг үүрэгжүүлж ажилладаг байна.

Нүүдэлчин фестивалийн 2024 оны “Зам сайжруулах” зардалд 100,000.0 мянган төгрөгөөр төсөвлөж СУГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/45 дугаар тушаалаар баталжээ. Фестивалийн Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн болох Зам тээврийн хөгжлийн яам нь “Хамтран ажиллах тухай” 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 02/2866 дугаар албан бичгийн хавсралтаар “Нүүдэлчин фестивалийн замын хэсэгчилсэн засварын ажлын төсөвт өртгийн тооцоог нийт 145,247.0 мянган төгрөг” байхаар төсвийн тооцоо хийж, уг ажлыг “Баянчандмань АЗЗА” ТӨХК-иар гүйцэтгүүлэхээр төлөвлөн, СУГ-т албан бичгийг хүргүүлсэн байна.

Зам тээврийн хөгжлийн яамны саналаар “Баянчандмань АЗЗА” ТӨХК-иар гүйцэтгүүлэх төсвийн зардал нь батлагдсан зардлаас өндөр дүнтэй байсан тул Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд байсан Налайх дүүргээс дэмжлэг үзүүлж ажиллах тухайгаа мэдэгдэн, Налайх дүүргийн Политехник коллежийн зүгээс техникийн туслалцаа үзүүлж хамтран ажиллах саналыг зөвлөлдөж байсан байна. Фестивалийн “Зам сайжруулах зардал”-ын 2024 оны гүйцэтгэлээр 19,427.4 мянган төгрөгөөр иргэн О.Базарвааньтай 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн СУГ/130 дугаар гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн байна.

Нүүдэлчин фестивалийн 2025 оны зам сайжруулах зардлыг Соёл, урлагийн газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Мөнгөн хөрөнгө зарцуулах тухай” А/35 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан зам сайжруулах зардалд өмнөх оны гүйцэтгэлээр 19,600.0 мянган төгрөг, хайрга, дайргын зардалд 5400.0 мянган төгрөг зарцуулахаар төсөвлөсөн байна.

Фестивалийн нийт зорчих хэсэг, авто зам, явган хүний замуудыг сайжруулах, хөрсөн замд тэгшилгээ хийх, заагдсан цэгүүдэд хайрга дэвсэх, суваг шуудуу ухах ажлыг 19,600.0 мянган төгрөгөөр өмнөх онд гүйцэтгэгчээр хамтран ажилласан иргэн О.Базарвааньтай 2025 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн СУГ/2025-123 дугаар гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн байна.

Зорчих хэсэг, авто зам, явган хүний замуудыг сайжруулах, хөрсөн замд тэгшилгээ хийх, заагдсан цэгүүдэд хайрга, дайрга нийлүүлэх, зөөж тээвэрлэх ажлыг 5400.0 мянган төгрөгөөр иргэн П.Шинэбаатартай 2025 оны 08 дугаар сарын 14-ны СУГ/2025-125 дугаар гэрээг байгуулж, гүйцэтгүүлжээ.

3.3. Гэрэл, гэрэлтүүлэг, цахилгааны утсыг худалдан авсан зардлын тухай

Нүүдэлчин фестивалийн тохижилтод зориулж 2023 онд Сондор гэрэлтүүлэг ХХК-аас 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн СУГ/2023-97 дугаар гэрээгээр 80 ширхэг нараар цэнэглэдэг 90см-тай гэрлийг нэгж үнийг нь 150.0 мянган төгрөгөөр, 60 см-тай 80 ширхэг гэрлийг нэгж үнийг нь 90.0 мянган төгрөгөөр, нийт 160 ширхэг гэрлийг 19,200.0 мянган төгрөгөөр худалдан авсан. Харин 2024 онд шинээр гэрэл худалдаж аваагүй ба зөвхөн суурилуулах зардлыг тусгасан байна.

Нүүдэлчин фестивалийн 2 жилийн өмнө худалдан авсан 90 см-тай 80 гэрлээс 40 гэрэл ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул 2025 онд Соёл, урлагийн газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Мөнгөн хөрөнгө зарцуулах тухай” А/35 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан зардалд Нүүдэлчин фестивалийн гудамжны замын гэрэлтүүлэг суурилуулах зардал (нарны зайн, бага оврын зөөврийн гэрэл) 6400.0 төгрөгийн төсөв батлагдсан байна. Тус төсвийн хүрээнд 6,400.0 мянган төгрөгийн өртөгтэй 32 ширхэг нарны гэрлээр ажилладаг явган гэрэлтүүлгийг Миг Степ ХХК-аас худалдан авч, суурилуулжээ. Нэг ширхэг зүлэгний гэрлийн нэгж үнэ 200.0 мянган төгрөг байна.

Миг степ ХХК нь худалдааны гэрэл, гэрэлтүүлгийн чиглэлийн худалдаа эрхэлдэг барилгын материалын худалдаа болон төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа хийх зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байна.

Фестивалийн нийт талбайг цахилгаанаар хангах генераторыг Монхорус ХХК-аас түрээсэлсэн байна. Тус компанитай 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн СУГ/2025-224 дүгээр гэрээг 16,920.0 мянган төгрөгөөр гэрээлжээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын 2025 оны ... сарын ... ны өдрийн дугаар гэрээний нэгдүгээр хавсралт

“НҮҮДЭЛЧИН” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛИЙН НИЙТ ТАЛБАЙГ ЦАХИЛГААНААР ХАГАХ ДИЗЕЛЬ ГЕНЕРАТОР (ТҮРЭЭС)-ЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Хугацаа	Нэгжийн үнэ	Цагт зарцуулах шатахуун	Нийт үнэ
Нэг. Дизель үүсгүүрийн түрээс							
1	275kVa/220kW	хоног	2	3	880,000	30-34л	5,280,000
Хоёр. Шатахууны зардал							
3	Шатахуун	литр	3,300		2,800		9,240,000
Гурав. Тээврийн зардал							
4	Генераторын одператор	ширхэг	2	3	400,000		2,400,000
Нийт дүн							16,920,000

Тус компани нь цахилгаан эрчим хүчний хангамж, цахилгааны тоног төхөөрөмж (генератор) борлуулалт, нийлүүлэлт суурилуулалт болон түрээсийн үйл ажиллагааг 1997 оноос хойш явуулж буй туршлагатай байгууллага байна.

Дөрөв. Гомдолд дурдсан “...Ж.Насанжаргал нь 2025 онд Нүүдэлчин наадмаар 102 гэрээ, 2024 он 44, 2023 онд 48 гэрээг хийсэн. Гэрээ хийхдээ санхүүгийн анхан шатны баримтыг хуурамчаар бүрдүүлэх, тухайн хүнээс ашиг хүртэж хувь авах үйлдэл нь илт байдаг. Мөн зах зээлийн үнээс хэд дахин өндөр үнээр эд материал авдаг. Жишээ нь 5 ханатай 3 гэрийг 16.0 сая төгрөгөөр, гэрийн тавилгыг 8.0 саяар худалдан авсан. Монгол гэрийг сурталчлан таниулах нэрийдлээр 5.0 сая төгрөг гэх мэтээр ажил төсвийг өөртөө зохиож, төсвийн мөнгийг бусдаар дамжуулан буцааж авдаг. Энэ бол цөөн жишээ юм..” гэсэн асуудлыг шалгахад:

4.1 Соёлын биет бус өвийн бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Насанжаргалын хийсэн гэрээний тухай.

ЗГХА-Соёл урлагийн газрын Соёл, соёлын өвийн хэрэгжилтийн газрын Соёлын биет бус өвийн бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Насанжаргал нь тус агентлагт 2022 оны 5 дугаар сараас хойш тасралтгүй ажиллаж байна. Соёл, соёлын өвийн хэрэгжилтийн газар нь Нүүдэлчин фестивалийг зохион байгуулах чиг үүрэгтэй байна. Ж.Насанжаргал нь Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Ажлын дэд хэсэг

байгуулах тухай” А/211 дүгээр тушаалаар фестивалийн зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар томилогдон ажиллажээ.

Соёлын биет бус өвийн бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Насанжаргал нь 2023 онд фестивальтай холбоотой гэрээг боловсруулах ажилд оролцсон боловч гэрээ байгуулж гэрээнд гарын үсэг зураагүй, харин 2024 онд 43 гэрээ боловсруулж, байгууллагын даргын баталсан 1 гэрээнд захиалагч талыг төлөөлж гарын үсэг зурсан. Мөн 2025 онд байгууллагын даргын баталсан 64 гэрээнд захиалагч талыг төлөөлж гарын үсэг зурсан байна.

Байгууллагыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан буюу тус агентлагийн төсвийн шууд захирагч нь гэрээ бүрийг баталж, гарын үсэг зуран, тамга дарж баталгаажуулсан. Гэрээ бүрт захиалагч талыг төлөөлж гэрээ байгуулахад тус агентлагийн чиг үүргийн хүрээнд хариуцсан нэгжийн дарга болон чиг үүргийн хүрээнд хариуцсан мэргэжилтний хамтаар гарын үсэг зурсан нь хууль тогтоомжид нийцсэн гэж үзэж байна.

4.2. Таван ханатай гэр, гэрийн тавилга авсан зардлын тухай

Гадаад оролцогчдын өртөө, гэрийн түрээсийн зардалд 16,000.0 мянган төгрөг төсөвлөгдсөн байна. Байгууллагын нягтлан бодогчийн санаачлагчаар төсөвлөсөн зардалд багтаан гэр түрээслэхээр биш шинээр гэр худалдан авч дараа жилүүдэд дахин дахин ашиглах саналыг гаргасны дагуу байгууллагын даргын зүгээс тус саналыг дэмжсэнээр түрээслэхээр тусгагдсан төсөвт багтаан Бат уянга гэр ХХК-тай 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдөр СУГ/2025-162 дугаар гэрээ хийж, шинээр 3 гэр худалдан авч, үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Худалдан авсан 3-н гэрийн нэгж үнэ 4,000.0 мянган төгрөг буюу нийт 12,000.0 мянган төгрөгийн худалдан авалтыг хийжээ. Үлдсэн 4,000.0 мянган төгрөгөөр гэр барих, гэр тээвэрлэх зардал, 1 гэрийг 3 өдөр түрээслэхээр гэрээнд тусган, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллажээ.

Зах зээл дээр худалдаалж буй монгол гэрийн дундаж үнэ 3-5 сая төгрөгийн үнэ ханштай байгаа нь зах зээлийн үнээс өндөр биш буюу дундаж үнэтэй байна.

Иргэн Д.Батдоржоос 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн СУГ/2025-161 дүгээр гэрээгээр сийлбэртэй гэрийн 9 ширээ, 27 сандлыг 7,110.0 мянган төгрөгөөр худалдан авч тээврийн зардал 890.0 байхаар гэрээлж гүйцэтгүүлсэн байна.

Монгол гэрийг сурталчлан таниулах 5.0 сая төгрөгийн ажлыг Ж.Насанжаргал хариуцан хэрэгжүүлээгүй байна.

Тав. Гомдолд “...С.Сувд-Эрдэнэ нь “Нүүдэлчин” наадмаар 32 гэрээг байгуулсан. Хэвлэл мэдээллийн байгууллагуудаар мэдээлэл түгээх нэрээр 300 орчим сая төгрөгийг тендерийн хуулийг зөрчиж, зориудаар нийт үнийн дүнг 20 саяас доош болгож сонгон шалгаруулалтгүй гэрээ хийсэн. Мөн оролцогч төлөөлөгчдөд өгөх гарын бэлгийн багцыг зах зээлийн үнээс хэд дахин үнээр тендергүй худалдан авалт хийсэн. 2025 оны Нүүдэлчин наадмын А/06, А/35 дугаар тушаалуудаар дээрх үйл ажиллагаанууд хийгдсэн...” гэсэн асуудлыг шалгахад:

5.1.Маркетинг, контент, сурталчилгааны зардлын тухай

Тус байгууллагын Захиргаа удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Сувд-Эрдэнэ нь 2025 оны “Нүүдэлчин” фестивалийн үеэр Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Цэнд-Аюушийн баталсан 29 гэрээнд захиалагч байгууллагыг төлөөлөн гарын үсэг зурсан.

Маркетинг сурталчилгаа контент үйлдвэрлэл, баримтжуулалтын ажлын дэд хэсгийг С.Сувд-эрдэнэ ахалж, нарийн бичгийн даргаар Б.Мөнх-Учрал ажилласан ба Нүүдэлчин фестивалийн Маркетинг, контент, сурталчилгааны Худалдан авах ажиллагааны Үнэлгээний хороонд орж ажиллаагүй байна.

Соёл, урлагийн газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн “Мөнгөн хөрөнгө зарцуулах тухай” А/24 дүгээр тушаалын хавсралтаар баталсан зохион байгуулалтын зардалд Маркетинг, контент, сурталчилгааны 348,440.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан ба 7 ажил үйлчилгээг 29 байгууллагатай гэрээлж, гүйцэтгэлээр 327,580.0 мянган төгрөг гарч, гэрээ дүгнэх актаар баталгаажуулжээ.

Маркетинг, контент, сурталчилгааны 348,440.0 мянган төгрөгийн төсвөөс худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт зохион байгуулах шаардлагатай 303,300.0 мянган төгрөгийн дараах 3 ажил үйлчилгээнд тендер зарласан боловч амжилтгүй болсон. Дахин тендер зарлах хугацаагүй шалтгаанаар тус ажил үйлчилгээг шууд гэрээгээр гүйцэтгүүлсэн байна.

Маркетинг, контент, сурталчилгааны зардлаас худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт зарласан жагсаалт

Хүснэгт 4 /мянган төгрөгөөр/

№	Тендерийн нэр	Тендерийн дугаар	Мөнгөн дүн	Тайлбар
1	Маркетингийн сурталчилгаа, контент бүтээх ажил	СУГ/20250303057	195,000.0	1 байгууллага тендерт оролцсон боловч шалгараагүй
2	Портер, мэдээ бэлтгэх, сошиал сувгаар түгээх	СУГ/20250303058	73,300.0	Шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй
3	Шууд дамжуулалт	СУГ/20250303059	35,000.0	Шалгаруулалтад нэг ч тендер ирүүлээгүй
Нийт дүн			303,300.0	

5.2.Өвлөн уламжлагчдыг алдаршуулах зардлын тухай

Нүүдэлчин фестивалийн Соёл, урлагийн газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Мөнгөн хөрөнгө зарцуулах тухай” А/35 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өвлөн уламжлагчдыг алдаршуулах зардал”-д 3 дэд бүлгийн 85,000.0 мянган төгрөг төсөвлөгдсөн ба гүйцэтгэлээр 84,522.0 мянган төгрөгийн бараа, ажлыг 5 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаар гүйцэтгүүлсэн байна.

Хүснэгт 5 /мянган төгрөгөөр/

№	Зардлын утга	Мөнгөн дүн	Гэрээлсэн байгууллага	Гэрээний огноо, дугаар	Гэрээний дүн
1	Аймаг, нийслэлийн оролцогчдын мерч бүтээгдэхүүн	60,000.0	Д.Төртогтох	2025/08/20, СУГ/2025-207	12,000.0
			Монголын үндэсний уламжлалт уран хатгамал ТББ	2025/08/20, СУГ/2025-209	25,200.0
			БОСА КОНДИТЕР ХХК	2025/08/20, СУГ/2025-219	22,320.0
2	Гадаад оролцогчдын мерч бүтээгдэхүүн	10,000.0	Тулга гоёл трейд ХХК	2025/8/26, СУГ/2025-236	9,612.0

3	Хүндэт зочдын мерч бүтээгдэхүүн	15,000.0	Түмэн Нүнжиг ХХК	2025/08/28/, СУГ/2025-237	15,390.0
Тушаалын дүн		85,000.0	Гэрээний дүн		84,522.0

Аймаг, нийслэлийн оролцогчдын мерч бүтээгдэхүүн худалдан авах бүтээгдэхүүний 60,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зарласан боловч тендерт нэг ч байгууллага материалаа ирүүлээгүй учир тендер амжилтгүй болсон байна. Тус тендерт С.Сувд-Эрдэнэ оролцоогүй байна.

Харин С.Сувд-Эрдэнэ нь Боса кондитер ХХК, иргэн Д.Төртогтох нартай аймаг нийслэлийн оролцогчдын мерч бүтээгдэхүүн худалдан авах Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Цэнд-Аюушийн баталсан гэрээнд, захиалагч талыг төлөөлж гарын үсэг зуржээ.

Боса кондитер ХХК-тай гэрээлсэн 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн СУГ/2025-219 дүгээр гэрээгээр шар сүүний чихрийн холимог 1200 ширхгийг нэгж үнэ нь 8800 төгрөгөөр, Монконди холимог чихрийг 1200 ширхгийг нэгж үнэ нь 9800 төгрөг нийт 22,320.0 мянган төгрөгөөр худалдан авахаар гэрээлжээ. Иргэн Д.Төртогтохтой 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн СУГ/2025-207 дугаар гэрээгээр 1200 ширхэг нэгж үнэ нь 10,000 төгрөгийн өртөгтэй нийт 12,000.0 мянган төгрөгийн чихэр хийх баадан уутыг урлуулж, хүлээн авч Гэрээ дүгнэх акт үйлдсэн байна. Эдгээр бүтээгдэхүүнийг ерөнхий ажлын хэсгийн шийдвэрээр худалдан авахаар тохиролцож шийдвэрлэсэн байна.

Зах зээлийн үнэ болон тухайн бүтээгдэхүүний үнийг судлан үзэхэд зах зээл дээр худалдаалагдаж буй жишиг үнэтэй ойролцоо байна.

ДҮГНЭЛТ

“Иргэний гаргасан гомдлын дагуу засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Соёл, урлагийн газрын зохион байгуулсан “Нүүдэлчин” наадмын төсвийн зарцуулалтын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалт хийх удирдамж”-ын хүрээнд Авлигатай тэмцэх газрын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 05/19641 дүгээр албан бичигт дурдагдсан асуудлаар дотоод хяналт шалгалт хийж дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Нүүдэлчин фестивалийг зохион байгуулахад шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Соёл урлагийн газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/44 дүгээр тушаалаар баталсан. Үнэлгээний 3 хороо “Нүүдэлчин” фестивалийн 1,079,311.0 мянган төгрөгийн 15 бараа, ажил, үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 12 багцтай 371,000.0 мянган төгрөгийн төсөвтэй “Оролцогч зохион байгуулагч нарын хоол үйлчилгээний тендер”, 16,786.0 мянган төгрөгийн төсөвтэй “Тээврийн үйлчилгээ”-ний тендер гэсэн 2 тендер амжилттай болж, гэрээ хийгдсэн байна. Гадаад оролцогч нарын байр, гадаадын оролцогч нарын автомашин түрээсийн үйлчилгээ гэсэн 2 тендер тус бүр 1 оролцогч оролцож баримт материал дутуу ирүүлсэн шалтгаанаар сонгон шалгаруулалтад тэнцээгүй байна. Бусад бараа, ажил, үйлчилгээний тендер нь нэг ч оролцогч тендерт материал ирүүлээгүйгээс амжилтгүй болжээ. Мөн тендер зарлах шаардлагатай 310,900.0 мянган төгрөгний 8 ажил, үйлчилгээнд тендер зарлаагүй шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 31.1.Захиалагч ерөнхий гэрээний

- аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.
2. Худалдан авах ажиллагааны 3 үнэлгээний хороо 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдөр болон 13-ны өдөр сонгон шалгаруулалтыг зарлаж, 2025 оны 08 дугаар сарын 14-ны өдөр болон 15-ны өдөр тендерийг хааж, үнэлгээний хороонууд сонгон шалгаруулалтыг явуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн Харьцуулалтын аргыг сонгосон бол тус хуулийн “34.4. “Урилга хүргүүлсэн өдрөөс хойш ажлын таваас доошгүй өдрийн дараа үнийн санал дуудах ба үргэлжлэх хугацааг хоёроос доошгүй цаг байхаар урилгад заана.”, Шууд гэрээний аргыг сонгосон бол мөн хуулийн “35.9.Захиалагч хэлэлцээний үндсэн дээр баталсан тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим системд нийтэлж, тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын долоогоос доошгүй өдөр байхаар заана” гэсэн заалтыг мөрдөж ажиллагаагүй байна.
 3. Фестиваль зохион байгуулах зардлыг баталж, эрх шилжүүлсэн тушаалыг 2025 оны 03-р сарын 07-ны өдөр баталсан боловч санхүүжилтийн эрх нээлгэх явц удаашралтай байсан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Сангийн сайд уруу албан бичиг хүргүүлж, удаа дараа холбогдох уулзалт хийж байсан байна. Гэвч улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор эрх шилжүүлж байгаа санхүүжилтийн эрхийг 2025 оны 07 дугаар сарын 09-нд 2025 оны Төсвийн тухай хуульд тодотгол орсноор санхүүжилт нээгдэх боломжтой болсон байна. Мөн ЗГХА-Соёл, урлагийн газрын даргыг 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн Б/18 тушаалаар чөлөөлж төсвийн шууд захирагч солигдсон зэрэг нь Нүүдэлчин фестивалийн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах боломжийг хязгаарлажээ.
 4. Нүүдэлчин фестивалийн зохион байгуулалт, худалдан авах ажиллагааг хугацаа тулган зохион байгуулж байгаа нь хууль тогтоомжийг зөрчих төдийгүй тухайн байгууллагын зарим албан хаагчдыг ашиг сонирхолд өртсөн байж болзошгүй гэх хардалтад өртүүлдэг байна. Манай шалгалтаар байгууллагын санхүүгийн анхан шатны баримтад тулгуурлан дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцад илт ашиг сонирхлын шинжтэй зөрчил ажиглагдаагүй болно.
 5. Оролцогч, зохион байгуулагч нарын хоол үйлчилгээ (12 багц) тендерийг хуулийн дагуу урилга хүргүүлж, 9 байгууллага хэлэлцээрт оролцсон байна. Тендер нээхэд 1 оролцогч буюу “Номадс Хоспиталити ХХК” 12 багцад бүгдэд нь оролцохоор материалаа ирүүлж, сонгон шалгаруулалтад оролцон шалгарсан нь гомдолд дурдсан “...Хоолны тендерийг урьдчилан тохиролцож материалыг нь бэлдүүлснээр “Модерн Номадс” ХХК”-д өгсөн...” гэсэн нь үндэслэлгүй гэж үзэхээр байна.
 6. Нүүдэлчин фестивалийн цахим хуудсыг анх 2023 онд (nomadsworldfestival.com) “Богд вүүдс солюшн” ХХК-аар 4,400.0 мянган төгрөгөөр цахим хуудсыг шинээр хөгжүүлсэн байна. “Богд вүүдс солюшн” ХХК-тай байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтад домэйн хаягны төлбөрийг тусгаж, төлбөрийг гэрээний дагуу шилжүүлсэн байгаа боловч домэйн хаяг захиалагч байгууллага(Соёл, урлагийн газар)-ын нэр дээр бүртгэгдээгүй гүйцэтгэгч байгууллага (Богд вүүд солюшн)-ын нэр дээр бүртгэсэн байна. Захиалагч байгууллагын нэр дээр бүртгэгдээгүй учраас хостинг үйлчилгээний төлбөрийг төлөхөд хүндрэл үүссэн шалтгаанаар 2023 онд шинээр хөгжүүлсэн цахим хуудсыг ашиглалгүй, дахин “Вэб хөгжүүлэх зардал”-ыг 19,520.0 мянган төгрөгөөр төсөвлөн фестивалийн Вэб нээх(www.nwf.mn), хөгжүүлэх ажил гүйцэтгэх зорилгоор “Гэрэгэ пэй ХХК”-тай байгуулан, цахим хуудсыг дахин шинээр хөгжүүлсэн байна. Энэ нь Төсвийн

- тухай хуулийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалтыг мөрдөж ажиллагаагүй байна.
7. Фестиваль зохион байгуулагддаг Улаанбаатар хотын Налайх дүүрэг Тайж хайрхны бэл нь дэд бүтэц хөгжөөгүй, зам талбай байхгүй тал газар зохион байгуулагддаг ба фестивалийн үеэр жил бүр дэд бүтэц, тохижилтыг 2024, 2025 онуудад хийж ирсэн байна. Нүүдэлчин фестивалийн 2024 оны “Зам сайжруулах” зардалд 100,000.0 мянган төгрөгөөр төсөвлөж, Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн болох Зам тээврийн хөгжлийн яам нь “Нүүдэлчин фестивалийн замын хэсэгчилсэн засварын ажлын төсөвт өртгийн тооцоог нийт 145,247.0 мянган төгрөг” байхаар төсвийн тооцоо ирүүлсэн нь батлагдсан зардлаас өндөр дүнтэй байсан тул Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд байсан Налайх дүүргээс дэмжлэг үзүүлж ажиллах тухайгаа мэдэгдэн, Налайх дүүргийн Политехник коллежийн зүгээс техникийн туслалцаа үзүүлснээр, зардлыг хэмнэх боломжтой болж, гүйцэтгэлээр “Зам сайжруулах зардал”-д 2024 онд 19,427.4 мянган төгрөг, 2025 онд 19,600.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.
 8. Нүүдэлчин фестивалийн тохижилтод зориулж 2023 онд Сондор гэрэлтүүлэг ХХК-аас нийт 160 ширхэг гэрлийг 19,200.0 мянган төгрөгөөр худалдан авсан ба 2024 онд шинээр гэрэл худалдаж аваагүй байна. Нүүдэлчин фестивалийн 2 жилийн өмнө худалдан авсан 90 см-тай(зүлэгний гэрэл) 80 гэрлээс 40 гэрэл нь ашиглалтын явцад эвдэрч, гэмтэн шаардлага хангахгүй болсон тул 6,400.0 мянган төгрөгийн төсөв батлуулж, 32 ширхэг нарны гэрлээр ажиллах зүлэгний гэрлийг Миг степ ХХК-аас худалдан авсан байна. Харин 2025 онд цахилгааны утас худалдан аваагүй байна.
 9. Соёлын биет бус өвийн бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Насанжаргал нь 2023 онд фестивальтай холбоотой гэрээг боловсруулах ажилд оролцсон боловч гэрээ байгуулж гэрээнд гарын үсэг зураагүй, харин 2024 онд 43 гэрээ боловсруулж, байгууллагын даргын баталсан 1 гэрээнд захиалагч талыг төлөөлж гарын үсэг зурсан. Мөн 2025 онд байгууллагын даргын баталсан 64 гэрээнд захиалагч талыг төлөөлж гарын үсэг зурсан байна. Байгууллагыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан буюу тус агентлагийн төсвийн шууд захирагч Э.Цэнд-Аюуш гэрээ бүрийг баталж, гарын үсэг зуран, тамга дарж баталгаажуулсан. Гэрээ бүрт захиалагч талыг төлөөлж гэрээ байгуулахад тус агентлагийн чиг үүргийн хүрээнд хариуцсан нэгжийн дарга болон чиг үүргийн хүрээнд хариуцсан мэргэжилтний хамтаар гарын үсэг зурсан нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйл Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний бүрэн эрх 15.4.1 дах заалт “Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, Иргэний хуулийн 62 дугаар зүйл Хэлцэлд төлөөлөх, 42.2 дах “Энгийн хэлбэртэй бичгийн хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно”, 2.7 дахь заалт “Бичгээр хийсэн хэлцлийг хэд хэдэн хувь үйлдсэн бол талуудад үлдэх хувь дээр харилцан гарын үсгээ зурсан байвал хэлцэл хийсэн гэж үзнэ.” гэсэнтэй нийцсэн байна.
 10. Соёлын биет бус өвийн бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Насанжаргал нь Бат уянга гэр ХХК-тай 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдөр СУГ/2025-162 дугаар гэрээгээр 3-н гэрийн нэгж үнэ 4,000.0 мянган төгрөг буюу нийт 12,000.0 мянган төгрөгөөр, Иргэн Д.Батдоржоос 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн СУГ/2025-161 дүгээр гэрээгээр сийлбэртэй 9 ширээ, 27 сандлыг 7,110.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авахаар агентлагийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Цэнд-Аюушийн баталгаажуулсан гэрээний дагуу худалдан авсан байна. Худалдан авах ажиллагааг дангаар шийдвэр гаргаж хийгээгүй байна. Худалдан авсан гэрийн үнэ нь зах зээл дээр худалдаалж буй монгол гэрийн дундаж үнэ 3-5 сая төгрөгийн үнэ ханштай байгаа нь зах зээлийн

үнээс өндөр биш буюу дундаж үнэтэй байна. Насанжаргалын худалдан авах ажиллагаа хийсэн монгол гэр, гэрийн доторх ширээ, сандлын худалдан авалтын санхүүгийн анхан баримтын иж бүрдлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалт "Анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ийн 5 дахь заалт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана, дагуу бүрэн хангасан байна.

11. Тус байгууллагын Захиргаа удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Сувд-Эрдэнэ нь 2025 оны "Нүүдэлчин" фестивалийн үеэр агентлагийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Цэнд-Аюуш баталсан 29 гэрээнд захиалагч байгууллагыг төлөөлөн гарын үсэг зурсан. Маркетинг сурталчилгаа контент үйлдвэрлэл, баримтжуулалтын ажлын дэд хэсгийг С.Сувд-эрдэнэ ахалж, нарийн бичгийн даргаар Б.Мөнх-Учрал ажилласан ба Нүүдэлчин фестивалийн Маркетинг, контент, сурталчилгааны Худалдан авах ажиллагааны Үнэлгээний хороонд орж ажиллаагүй байна. Маркетинг, контент, сурталчилгааны 348,440.0 мянган төгрөгийн төсвөөс худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт зохион байгуулах шаардлагатай 303,300.0 мянган төгрөгийн дараах 3 ажил үйлчилгээнд тендер зарласан боловч амжилтгүй болсон шалтгаанаар ажил үйлчилгээг шууд гэрээгээр гүйцэтгүүлсэн байна.
12. Нүүдэлчин фестивалийн "Өвлөн уламжлагчдыг алдаршуулах зардал"-д 3 дэд бүлгийн 85,000.0 мянган төгрөг төсөвлөгдсөн ба гүйцэтгэлээр 84,522.0 мянган төгрөгийн бараа, ажлыг 5 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаар гүйцэтгүүлсэн байна. Аймаг, нийслэлийн оролцогчдын мерч бүтээгдэхүүн худалдан авах бүтээгдэхүүний 60,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зарласан боловч тендерт нэг ч байгууллага материалаа ирүүлээгүй учир тендер амжилтгүй болсон байна. Тус тендерт С.Сувд-Эрдэнэ оролцоогүй байна. Зах зээлийн үнэ болон тухайн бүтээгдэхүүний үнийг судлан үзэхэд зах зээл дээр худалдаалагдаж буй жишиг үнэтэй ойролцоо байна.
13. Худалдан авах ажиллагаатай холбоотой дүгнэлт гаргуулах шаардлагатай бол Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 56 дугаар зүйл Худалдан авах ажиллагааны улсын байцаагч хэсгийн 56.5 дахь заалт "Улсын байцаагч оролцогчтой холбоотой дараах нөхцөлийн талаар дүгнэлт гаргана" гэсэн чиг үүргийн дагуу Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандан дүгнэлт гаргуулж болох боломжтой байна.

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

Дотоод хяналт шалгалтаар илэрсэн алдаа дутагдал, зөрчилд үндэслэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор холбогдох байгууллага, нэгжийн удирдлага, албан тушаалтанд дараах зөвлөмжийг хүргүүлэв. Үүнд:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт:

1. “Нүүдэлчин” фестивалийн зохион байгуулалт болон санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн “14.2.3. өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, “14.2.5. өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, “14.4. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэсэн эрх, үүргийн хүрээнд эрх шилжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
2. Төрийн болон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулийн “45.7.Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлэх” заалтыг мөрдөх;

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Соёл, урлагийн газрын дарга Г.Батхуяг, Санхүүгийн хэлтсийн дарга Р.Дулмаа, Ерөнхий нягтлан бодогч Б.Отгонжаргал нарт:

1. “Нүүдэлчин” фестивалийн зардлыг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6.4.1 дэх заалтыг тус тус баримтлан санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах;
2. “Нүүдэлчин” фестиваль зохион байгуулахтай холбоотой худалдан авах ажиллагааг Төрийн болон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуульд заасан хугацааг мөрдөж ажиллах боломжтой байхаар төлөвлөх;
3. “Нүүдэлчин” фестиваль зохион байгуулахтай холбоотой худалдан авах ажиллагааг Төрийн болон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулийн “10.5.Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно.” гэж заасныг мөрдөж ажиллах;
4. “Нүүдэлчин” фестивалийн санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн 5.1.4, 6.5.1 дэх заалтыг тус тус хэрэгжүүлж төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг албан хаагчдад нээлттэй мэдээлж, фестивалтай холбоотой аливаа шийдвэр, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд олон нийт болон албан хаагчдад ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар тайлагнах;
5. “Нүүдэлчин” фестивалийн цахим хуудсыг удаа дараа шинээр хөгжүүлж, төсвийг үр ашиггүй байдлаар зарцуулж буй байдлыг таслан зогсоож, хостинг үйлчилгээний зардлыг тусгадгүйгээс цахим хуудас устах эрсдэл үүссэн байгаад арга хэмжээ авч ажиллах;
6. Дотоод хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн өгсөн зөвлөмжийн талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжилтийг ханган, зөвлөмжийн хариуг 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор яамны ХШҮДАГ-т ирүүлэх.